

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

Огноо: 2012/01/17

Дугаар: 25

Улаанбаатар хот

“Чанарын албаны дүрэм батлах тухай”

Эрүүл мэндийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалтыг үндэслэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, дотоодын хяналтыг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Чанарын албаны дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Эрүүл мэндийн чанарын хяналтын зөвлөл, салбар зөвлөл, эрүүл мэндийн байгууллагууд дахь чанарын албад, мэргэжлийн хяналтын байгууллагуудын хамтран ажиллах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Гончигсүрэн), МХЕГ-ын Эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын газар (Н.Гансүх), ЗГХА-Эрүүл мэндийн газар (Ш.Энхбат)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ЭМЯ-ны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Жаргалсайхан), МХЕГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Я.Ариунзул)–т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2007 оны “Журам батлах тухай” 275, 2010 оны “Эмнэлгийн тусламж үйлчилгээний дотоодын хяналтыг эрчимжүүлэх тухай” 225 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ШАДАР САЙД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

М.ЭНХБОЛД

С.ЛАМБАА

"ЧАНАРЫН АЛБАНЫ ДҮРЭМ"

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Эрүүл мэндийн байгууллагууд дахь чанарын алба нь тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавих үүрэг бүхий нэгж мөн.
- 1.2 Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан эрүүл мэндийн бүх байгууллагуудад чанарын алба ажиллана.
- 1.3 Чанарын алба нь Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана.
- 1.4 Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, нийгмийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, клиник, хувийн хэвшлийн эмнэлэг, түргэн тусламжийн төв, сувилалд тухайн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйлчлэх хүрээний хүн амын тоо зэргээс хамаарч чанарын албыг 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж болно.
- 1.5 1.4-д заасан чанарын алба нь энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллах ба чанарын албаны гишүүдийн ажил үүргийг зохицуулан, үйл ажиллагааны чиглэлийг бүрэн гүйцэтгэхээр зохион байгуулсан байна.
- 1.6 Чанарын алба нь тасаг, нэгжүүдэд чанарын баг байгуулж ажиллана.
- 1.7 Тусгай мэргэжлийн төв, төв эмнэлгүүдийн чанарын албаны дарга нарыг сэлгүүлэн ажиллуулна.
- 1.8 Сэлгүүлэн ажиллуулах үйл ажиллагааны зааврыг ЗГХА-Эрүүл мэндийн газар баталж, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хоёр. Чанарын албаны орон тоо, бүтэц

2.1. Эрүүл мэндийн байгууллагууд дахь чанарын алба нь дараах бүтэц, орон тоогоор ажиллана.

2.1.1 Орон тооны гишүүд :

- Эмнэлгийн чанарын албаны дарга
- Чанарын менежер
- Лавлагаа үйлчилгээний ажилтан

2.1.2 Орон тооны бус гишүүд:

- Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга/ нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга
- Сувилахуйн албаны дарга
- Эмгэг судлаач эмч
- Тархвар судлаач эмч
- Мэдээллийн мэргэжилтэн статистикч их эмч
- Эм зүйч
- Эрүүл мэндийн даатгалын эмч

Гурав. Чанарын албаны баримтлах зарчим

Дараахь үндсэн зарчмыг баримтлан ажиллана.

3.1 Хууль, тогтоомжийг эрхэмлэн дээдлэх

3.2 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг баримтлах

3.3 Багаар ажиллах

3.4 Ил тод, тэгш шударга байх

3.5 Нотолгоонд тулгуурлах

3.6 Хараат бус

Дөрөв. Чанарын албаны гишүүдэд тавигдах шаардлага, томилох зарчим

4.1. Чанарын албаны гишүүдэд тавигдах шаардлага:

4.1.1 Албаны дарга нь эрүүл мэндийн байгууллагад 8-аас доошгүй жил ажилласан, эрдмийн буюу мэргэжлийн зэрэг цолтой, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын чиглэлээр 3-аас дээш жил ажилласан туршлагатай, багаар ажиллах чадвартай, ёс зүйн алдаа зөрчил гаргаж байгаагүй

4.1.2. Албаны менежер нь эрүүл мэндийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, эрдмийн буюу мэргэжлийн зэрэг цолтой, эрүүл мэндийн тусламж,

үйлчилгээний чанарын чиглэлээр 1-ээс дээш жил ажилласан туршлагатай, багаар ажиллах чадвартай, ёс зүйн алдаа зөрчил гаргаж байгаагүй

4.2. Чанарын албаны дарга, гишүүдийг томилох:

4.2.1. Тусгай мэргэжлийн төв, төв эмнэлгийн чанарын албаны даргын албан тушаалд сонгон шалгаруулах зарчмаар томилно.

4.2.2 ЗГХА-Эрүүл мэндийн газар нь сонгон шалгаруулах журмыг батлан хэрэгжүүлнэ.

4.2.3 Сонгогдсон чанарын албаны даргыг тусгай мэргэжлийн төв, төв эмнэлгүүдийн дарга, захирал баталгаажуулж, томилно.

4.2.4 Бусад чанарын албаны дарга, гишүүдийг дүрмийн 4.1-д заасан шаардлагыг үндэслэн тухайн байгууллагын удирдлага томилно.

Тав. Байгууллагын удирдлагын эрх, үүрэг

5.1 Байгууллагын дарга, захирал нь тухайн байгууллагын тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

5.2 Тасаг нэгжүүдэд чанарын баг ажиллуулах, чанарын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааг байгууллагынхаа бүх түвшинд зохион байгуулахад бүх талаар дэмжинэ.

5.3 Чанарын албыг бие дааж ажиллах орчин, нөхцөл, бололцоо, дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана.

5.4 Чанарын албаны үзлэг, хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг шийдвэрлэх арга хэмжээг шуурхай авч ажиллана.

5.5 Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, урамшуулах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэн, зарцуулах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Зургаа . Чанарын албаны үйл ажиллагааны чиглэл

6.1 Чанарын алба нь тус дүрмийн 1.1-д заасан тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавих үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

- 6.2 Чанарын алба нь чанарын төлөвлөгөө, чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлэлт дүгнэлт өгөх, түүний мөрөөр цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- 6.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг мөрдүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах,
- 6.4 Хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, мэргэжлийн хяналтын шалгалтын дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах,
- 6.5 Эрүүл мэндийн байгууллага дахь мэргэжлийн хороо, алба, комиссын /ёс зүй, эмэн эмчилгээ, халдвар хяналтын хороо гм/ уялдаа холбоог хангах, үйл ажиллагаанд хяналт тавих, чанар сайжруулах үйл ажиллагаанд татан оролцуулах,
- 6.6 Алдаа зөрчлийг бүртгэх, ижил мэргэжилтний үзлэг хийх, эрсдэлийн блог ажиллуулах, эмнэл зүйн алдааны товхимол гаргах зэрэг тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах олон улсын туршлагыг нэвтрүүлэх,
- 6.7 Үйлчлүүлэгч болон эмч, мэргэжилтний аюулгүй байдалд онцгой анхааран, аюул эрсдлээс хамгаалах, эмнэлгээс шалтгаалах халдварт өртөхгүй байх бүхий л арга хэмжээнд хяналт тавьж ажиллах,
- 6.8 Тухайн байгууллагын тусламж, үйлчилгээний чанарын мэдээллийн сан байгуулж, сайн туршлагыг дэлгэрүүлэх, алдаанаас суралцах орчинг бүрдүүлэх,
- 6.9 Байгууллагын цахим хуудсанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл тавих, хамтын мэдээлэл солилцох, суралцах, эргэх холбооны хэрэгсэл болгох зорилго бүхий чанарын буланг тогтмол ажиллуулах,
- 6.10 Байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг холбогдох нэгжтэй хамтран шийдвэрлэх,
- 6.11 Эмч, эмнэлгийн ажилтнуудад чанарын сургалт зохион байгуулах, тасралтгүй суралцах орчинг бүрдүүлэх,
- 6.12 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төсвийг үр ашигтай зарцуулах,
- 6.13 Олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран чанар сайжруулах арга хэмжээг зохион байгуулах,
- 6.14 Үйлчлүүлэгчидтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, сэтгэл ханамжийн судалгаа явуулж үр дүнг тооцон ажиллах зэргээр тусламж, үйлчилгээний чанарыг

сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,

6.15 Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны эрүүл мэндийг сайжруулах үйл ажиллагааны үр дүнг хянах,

6.16 Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дотоодын хяналт тавих,

Долоо.Чанарын албаны дарга, гишүүдийн эрх, үүрэг

7.1Эмнэлгийн чанарын албаны дарга, менежерийн үүрэг

7.1.1 Байгууллагын чанарын албаны өдөр тутмын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах,

7.1.2 Төлөвлөгөөт болон явцын үнэлгээ, хяналт хийж, үр дүнг тооцон, эргэн мэдээлж байх,

7.1.3 Байгууллагын мэргэжлийн баг, тасаг, нэгжийн чанарын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, биелэлтэд хяналт тавих,

7.1.4 Чанарын багийн тайланг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцон ажиллах,

7.1.5 Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр санал боловсруулан удирдах ажилтанд танилцуулан шийдвэрлүүлэх,

7.1.6 Чанар сайжруулах арга хэрэгслүүдийг сургах үйл ажиллагааг зохион байгуулах,

7.1.7 Чанарын сургалтыг тогтмолжуулан жилд 2-оос доошгүй удаа чанарын өдөрлөг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах

7.1.8 Алдааны болон эрсдлийн мэдээний сан ажиллуулж алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ашиглах

7.2Эмнэлгийн чанарын албаны дарга, менежерийн эрх

7.2.1. Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр сургалтад хамрагдах, мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх,

7.2.2. Хөндлөнгийн хяналтын байгууллагад хандан үзлэг, хяналт хийлгэх, заавар зөвлөгөө авах, хамтран ажиллах,

7.2.3 Төлөвлөгөөт болон явцын үнэлгээ, үзлэг, шалгалт хийх, үр дүнг тооцоход холбогдох мэргэжилтнүүдийг татан оролцуулах,

7.2.4 Тусламж, үйлчилгээний үйл явц, үр дүнтэй холбоотой мэдээллийг шаардлагатай эх үүсвэрээс гаргуулан авах

7.2.5 Тусламж, үйлчилгээний чанарын урамшуулал олгох санал дэвшүүлэн шийдвэрлүүлэх

7.2.6 Чанарын албаны үйл ажиллагаанд иргэн, гэр бүл, хамт олныг оролцуулах, эрүүл ахуй, халдвар хамгааллын хэвийн нөхцөлийг хангуулахад чиглэгдсэн заавар, зөвлөгөө өгөх, шаардлага тавих,

7.3 . Лавлагаа, үйлчилгээний ажилтны эрх, үүрэг

7.3.1 Чанарын албаны хурлыг зохион байгуулах, дотоод бичиг хэргийг хариуцаж ажиллах,

7.3.2 Байгууллагын цахим хуудасны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын буланг эрхлэн ажиллуулах,

7.3.3 Үйлчлүүлэгчдийн санал, хүсэлтийг хүлээн авах байнгын нээлттэй орчин бүрдүүлэн ажиллах /нээлттэй утас, санал гомдлын дэвтэр, хайрцаг ажиллуулах, иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах .. гм/,

7.3.4 Үйлчлүүлэгчийн санал, хүсэлтийг хүлээн авч нэгтгэн, чанарын албаны дарга, менежерт тайлагнах, үр дүнг мэдээлэх,

7.3.5 Үйлчлүүлэгчдийн эмнэлэг доторх урсгалыг зохицуулах, мэдээллээр хангах,

7.3.6 Үйлчлүүлэгчдийн хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор эмч, эмнэлгийн ажилтнуудад шаардлага тавих,

7.3.7 Сургалтад хамрагдах, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх,

7.4 Чанарын албаны гишүүдийн эрх, үүрэг

7.4.1 Чанарын албаны гишүүд нь тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах аливаа үйл ажиллагааг зохион байгуулах, хамтарсан хяналт, үзлэг, шалгалт хийх, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, арилгуулах, заавар, зөвлөмж өгөх, чанар сайжруулах арга хэрэгслийг хэрэглэх, чанарт дүн шинжилгээ хийх, байгууллагын чанарыг сайжруулах чиглэлээр санал, хүсэлтээ холбогдох байгууллагуудад хүргүүлэх, шийдвэрлүүлэх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

7.4.2 Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга нь тухайн байгууллагын тусламж, үйлчилгээний чанарын алба, багийн үйл ажиллагааг удирдан, чиглүүлж, холбогдох талуудын уялдаа холбоог ханган, хамтран ажиллана.

7.4.3 Сувилахуйн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг сувилахуйн албаны дарга хэрэгжүүлнэ.

7.4.4 Халдвар, хяналтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, эмнэлгээс шалтгаалсан халдвар, үйлчлүүлэгч болон эмч мэргэжилтний аюулгүй байдлын эрсдлийг бууруулах ажлыг тархвар судлаач эмч зохион байгуулна.

7.4.5 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, гаж нөлөөг судлах, тендерээр орж ирж буй эмийн чанар, эмийн жор бичилт, эмийн эмчилгээний чанар, аюулгүй байдалд эм зүйч хяналт тавьж ажиллана.

7.4.6 Албаны үйл ажиллагаанд шаардлагатай, тоо мэдээлэл цуглуулан, шалгуур үзүүлэлт боловсруулах, дүн шинжилгээ хийхэд мэдээллийн мэргэжилтэн статистикч их эмч дэмжлэг үзүүлэн ажиллана.

7.4.7 Эмч, мэргэжилтнийг эмнэлзүйн алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх, алдаанаасаа суралцах үйл ажиллагааг эмгэг судлаач эмч чиглүүлэн ажиллана.

7.4.8 Даатгалын байгууллагатай хамтран ажиллах, даатгуулагчийн тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих чиг үүргийг эрүүл мэндийн даатгалын эмч хэрэгжүүлнэ.

Найм. Тасаг, нэгжийн чанарын багийн эрх, үүрэг

8.1 Тасаг, нэгжийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагаа, дотоод хяналтыг тасаг, нэгжийн чанарын баг хариуцаж, зохион байгуулна.

8.2 Тасаг, нэгжийн түвшинд тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх, тайланг сар тутам чанарын албанд хүргүүлэх,

8.3 Тасгийн хурлаар тусламж, үйлчилгээний чанарын асуудлыг тогтмол хэлэлцэн, шийдвэрлэх,

8.4 Тасгийн тусламж, үйлчилгээний чанартай холбоотой тулгамдсан асуудлыг чанарын албанд тавьж шийдвэрлүүлэх,

8.5 Байгууллага дахь мэргэжлийн хороо багтай хамтран ажиллах,

8.6 Эмч, мэргэжилтний чанар сайжруулах үйл ажиллагааг сурталчлах, урамшуулах,

Ёс. Чанарын албаны хамтын ажиллагаа

9.1 Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эрүүл мэндийн чанарын хяналтын зөвлөл, ЗГХА-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэс, мэргэжлийн хяналтын байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

9.2 Мэргэжлийн хяналтын байгууллага нь аливаа аюул эрсдэл болон зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, эрсдлийн түвшинг бууруулах, байгууллагын дотоод хяналт, хариуцлагыг өндөржүүлэх, зөвлөн туслах арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

9.3 Мэргэжлийн хяналтын байгууллага нь эрүүл мэндийн байгууллагуудын чанарын албаны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, үр дүнг баталгаажуулна.

9.4 Мэргэжлийн хяналтын байгууллага нь Захиргааны хариуцлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу ажиллан, эрүүл мэндийн байгууллагуудад чанар сайжруулах зөвлөмж хүргүүлэн, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

9.5 Чанарын алба нь дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулан, мэргэжлийн хяналтын байгууллагатай чанарын хяналт, шинжилгээ үнэлгээ, сургалтыг хамтран зохион байгуулна.

9.6 Чанарын алба нь тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад орчин үеийн нотолгоонд тулгуурласан арга, олон улсын стандарт, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох чиглэлээр санал хүргүүлж, шийдвэрлүүлэх, зөвлөмж авах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

9.7 Чанарын алба нь дэмжлэгт удирдлагаар хангагдах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай холбоотой дүрэм, журмыг боловсруулах, санал өгөх, сургалтанд хамрагдаж мэргэших зэрэг үйл ажиллагааг ЗГХА-Эрүүл мэндийн газартай хамтран хэрэгжүүлнэ.

9.8 ЭМЯ, ЗГХА-Эрүүл мэндийн газартай хамтран олон улсын хурал, семинар зохион байгуулж, оролцож болно.

9.9 ЗГХА-Эрүүл мэндийн газар нь чанарын албадын туршлага солилцох уулзалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

9.10 ЗГХА-Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагууд дахь чанарын албадыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг баталж, албадын үйл ажиллагааг үнэлэн, үр дүнг тооцон ажиллана.

9.11 ЗГХА-Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагууд дахь сайн туршлагын сан, алдааны мэдээний санг нэгдсэн удирдлагаар ханган ажиллуулна.

Арав. Чанарын албаны үйл ажиллагааны тайлан

10.1 Тусгай мэргэжлийн төв, төв эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдийн чанарын алба нь үйл ажиллагааны тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ЗГХА-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэст хүргүүлнэ.

10.2 Бусад чанарын алба нь үйл ажиллагааны тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Эрүүл мэндийн чанарын хяналтын салбар зөвлөлд хүргүүлнэ.

10.3 Эрүүл мэндийн чанарын хяналтын салбар зөвлөл нь чанарын албаны үйл ажиллагааны тайланг нэгтгэн, салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлангийн хамт жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ЗГХА-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтэст хүргүүлнэ.

10.4 ЗГХА-Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн чанарын хяналтын салбар зөвлөлүүдийн болон чанарын албадын тайланд дүн шинжилгээ хийж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зөвлөмжийг боловсруулан, байгууллагын цахим хуудсанд жил бүрийн 2 дугаар сард багтаан байршуулна.

10.5 ЗГХА-Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн чанарын хяналтын салбар зөвлөлийн болон чанарын албадын тайланг нэгтгэн, тусламж, үйлчилгээний чанарын чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал, зөвлөмжийг боловсруулан Эрүүл мэндийн чанарын хяналтын зөвлөлийн хурлаар жил бүрийн 2 дугаар сард багтаан хэлэлцүүлнэ.

Арван нэг. Чанарын албыг урамшуулах, хариуцлага тооцох

11.1 Эрүүл мэндийн яам, ЗГХА-Эрүүл мэндийн газар нь чанарын албаны

гишүүдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын чиглэлээр дотоод, гадаадын сургалт, семинар, туршлага судлах аялалд хамруулна.

11.2 ЗГХА-Эрүүл мэндийн газар чанарын албаны гишүүдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах арга хэрэгслийг ашиглах ур чадварыг дээшлүүлэх сургалтанд тогтмол хамруулна.

11.3 Байгууллагын удирдлага нь чанарын албаны дарга, гишүүдийн ажлын үр дүн, гүйцэтгэлээс хамааран урамшуулал олгоно.

11.4 Эрүүл мэндийн байгууллага нь чанарын албаны дарга, гишүүдийг шагнах, урамшуулах хүсэлтийг эрүүл мэндийн чанарын хяналтын салбар зөвлөлөөр дамжуулан ЗГХА-Эрүүл мэндийн газарт хүргүүлж болно.

11.5 Эрүүл мэндийн чанарын хяналтын зөвлөл нь ЗГХА-Эрүүл мэндийн газраас ирүүлсэн чанарын албадын гишүүдийг шагнах, урамшуулах тухай хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ

11.6 Чанарын албаны дарга, гишүүд нь энэхүү дүрэмд заасан зарчмын дагуу эрх, үүргийг хүлээн үйл ажиллагааг явуулах ба зөрчсөн тохиолдолд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журам болон холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Танилцуулга

Хүн амын эрэлт хэрэгцээнд тулгуурлан, чанартай, тэгш, хүртээмжтэй тусламж үйлчилгээг үзүүлэх, чанарыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй, үр ашигтай механизмыг дэмжих, хөгжүүлэх, чанар сайжруулах арга хэрэгсэлд сургах, чанарын чиглэлээр мэргэшүүлэх, чанарын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх зэрэг зорилтыг шийдвэрлэх нь энэхүү дүрмийг боловсруулах үндэслэл болсон юм.

Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 1992 оноос ЭМЯ-ны Чанарын алба, 1997 оноос чанарын менежерүүдийг ажиллуулж, 2000 оноос орон тооны бус чанарын алба, 2007 оноос орон тооны чанарын алба, 2008 оноос ЭМЯ-ны дэргэд Чанарын үндэсний зөвлөл ажиллуулж эхэлсэн байна. 2011 оны 349 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн чанарын хяналтын зөвлөл болгон өөрчлөн, ажлын албаар ЗГХА-ЭМГ-ын Эмнэлгийн тусламжийн хэлтэс ажиллах болсон.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, баталгаажуулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны стандарт, оношлогоо эмчилгээний түгээмэл үйлдлүүд, эмнэлзүйн удирдамжууд боловсруулж, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр”-ийг /2008-2013/ батлан хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2007 оны “Журам батлах тухай” 275, 2008 оны “Хөтөлбөр батлах тухай” 176, 2010 оны “Эмнэлгийн тусламж үйлчилгээний дотоодын хяналтыг эрчимжүүлэх тухай” 225, 2011 оны “Дүрэм батлах тухай” 349 дүгээр тушаалуудыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд цаашид Эрүүл мэндийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор эдгээр тушаал шийдвэрүүдийг нэгтгэх, шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалтыг үндэслэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2011 оны 08 сарын 31-ний 273 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "ЧАНАРЫН АЛБАНЫ ДҮРЭМ"-ийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т “... Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавих үүрэг бүхий албаны дарга, ажилтанд мэргэжлийн хяналтын байцаагчийн эрх олгож болно...” гэж заасныг үндэслэн улсын байцаагчийн эрхийг хэрхэн олгох талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын газрын дарга Н.Гансүх, улсын байцаагч нартай ажлын хэсгийн уулзалт, ярилцлагыг хийсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй. Иймд МХЕГ-ын дарга Р.Содхүүд Эрүүл мэндийн сайд С.Ламбаагаас хамтран ажиллах тухай 2011.11.21-

ны өдрийн 1а/3806 дугаар бүхий албан тоот хүргүүлж, хариуг 2011.11.28-ны өдөр авсан болно. Эрүүл мэндийн тухай хуулийн 42.2-т заасан дээрх заалт нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн заалтыг зөрчиж байгаа тул эрүүл мэндийн байгууллагын чанарын хяналтын ажилтнуудад байцаагчийн эрх олгох боломжгүй тухай хариу ирүүлсэн. Иймд ажлын хэсэг ЭМТХуулийн 42.2 дахь заалтын дагуу энэхүү дүрмийн төсөлд байцаагчийн эрх олгох тухай заалт оруулаагүй. Харин мэргэжлийн хяналтын газартай хамтран ажиллах талаар заалтуудыг /9.1-9.5/ оруулсан болно.

Энэхүү дүрмийн төслийн 1.1-т "...Чанарын алба нь тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавих үүрэг бүхий нэгж мөн. ..." гэж эрүүл мэндийн байгууллагууд дахь чанарын албаны чиг үүргийг тодорхой болгож, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны бүтэц, орон тоо /2-р зүйл/, үйл ажиллагааны чиглэл /6-р зүйл/-ийг гишүүд тус бүрээр заав.

Тусламж, үйлчилгээний чанарын удирдлага нь байгууллагын удирдлагатай салшгүй холбоотой тул удирдлагын эрх, үүрэгт //5-р зүйл/ байгууллагын тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах тухай заалтыг оруулав.

Чанарын албыг урамшуулах механизмыг тодорхой тусган /11-р зүйл/, чанарын хяналтын албадын чанар сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах зардлыг төсөвт суулган, зарцуулах талаар заалт /5.6, 6.12/ нэмэв.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн чанарын албадын дарга нарыг сонгон шалгаруулах зарчмаар томилж байх заалтыг /4.2/, сэлгүүлэн ажиллуулах талаар заалтуудыг /1.7-1.8/ шинээр боловсруулж тусгалаа.

Чанарын албаны үйл ажиллагааны тайланг нэгтгэх, үнэлгээ дүгнэлт өгөх нэгдсэн удирдлага, зохион байгуулалт байхгүй байгаа тул чанарын хяналтын албадын тайлагнах зарчмыг/10-р зүйл/ шинэчлэн боловсруулав.

Чанарын албаны хамтын ажиллагааны талаар заалтуудыг /9-р зүйл/ шинээр боловсруулан тусгалаа.

Дүрмийн төслийг 2011 оны 12 дугаар сарын 01-ны өдөр ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлөөр, 2011 оны 12 дугаар сарын 06-ны өдөр ЭМЯ-ны дэргэдэх Эрүүл мэндийн чанарын хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, гишүүдийн санал зөвлөмжийг тусган ажлын хэсэг дахин хянан боловсруулан, МХЕГ-аас санал авч тусгасан болно.

Санал зөвлөмжийн товчооныг хавсаргав.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ЭМЯ-НЫ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААС ГАРСАН САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ “ЧАНАРЫН АЛБАНЫ ДҮРЭМ”-ИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ӨӨРЧЛӨЛТ

№	Саналын утга	Тайлбар , өөрчлөлт
1	Албаны дүрмийн нэрийг хэрхэн оновчтой болгох талаар ажлын хэсэг дахин ярилцаж, шийдвэрлэх	Дүрмийн 1.1-т “...Чанарын алба нь тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавих үүрэг бүхий нэгж мөн...” гэж чанарын албаны үндсэн чиг үүргийг заасан тул тушаалын нэрийг “Чанарын албаны дүрэм” гэж өөрчлөв.
2.	Үйлчлүүлэгчийн оролцоог хангах заалт оруулж өгөх	6.14-д. “...Үйлчлүүлэгчидтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, сэтгэл ханамжийн судалгаа явуулж үр дүнг тооцон ажиллах зэргээр тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх...” гэж нэмэлт заалт оруулав.
3	Чанарын албадын үйл ажиллагааг хэн, хэрхэн үнэлэх талаар заалт оруулах	9.10-д “... ЗГХА-Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагууд дахь чанарын албадыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг баталж, албадын үйл ажиллагааг үнэлэн, үр дүнг тооцон ажиллана...” гэж нэмж тусгав.
4	Тендерээр оруулж ирж буй эмийн хяналтад хяналт тавих тухай оруулах	7.4.5-д “...Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, гаж нөлөөг судлах, тендерээр орж ирж буй эмийн чанар, эмийн жор бичилт, эмийн эмчилгээний чанар, аюулгүй байдалд эм зүйч хяналт тавьж ажиллана...” гэж өөрчлөв.
5	Чанарын албаны үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар заалт оруулах	6.7-д “...Үйлчлүүлэгч болон эмч, мэргэжилтний аюулгүй байдалд онцгой анхааран, аюул эрсдлээс хамгаалах, эмнэлгээс шалтгаалах халдварт өртөхгүй байх бүхий л арга хэмжээнд хяналт тавьж ажиллах..” тухай заалт нэмэв.
6	Эмнэлгийн чанарын албаны дарга, менежерийн үүрэгт	Төслийн 7.1.8-д “...Алдааны болон эрсдлийн мэдээний сан ажиллуулж

	орхигдсон зүйл байгаа эсэхийг нягтлах	алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ашиглах...” гэж нэмэв.
7	“Чанарын албаны хамтын ажиллагаа” бүлгийг нягтлах	9.8, 9.9, 9.10-т тус тус нэмэлт заалт оруулав.
8	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар заалт оруулах	6.15-д “...Эрүүл мэндийн сайн дурын идэвхтнийг хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйлст татан оролцуулж буй үйл ажиллагааг дэмжин ажиллах...”, 6.16-д “...Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дотоодын хяналт тавих..” заалт нэмэв.
9	Чанарын албаны үйл ажиллагаанд иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэж байх заалт оруулах	6.10-д “...Байгууллагын тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг холбогдох нэгжтэй хамтран шийдвэрлэх...” гэж нэмж тусгав.
10	Олон нийтэд тусламж, үйлчилгээний чанарын талаарх мэдээллийг хүргэх тухай заалт нэмэх	6.9-д “...Байгууллагын цахим хуудсанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл тавих, хамтын мэдээлэл солилцох, суралцах, эргэх холбооны хэрэгсэл болгох зорилго бүхий чанарын буланг тогтмол ажиллуулах...” тухай заалт байгаа ба 9.10-т “...ЗГХА-Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагууд дахь сайн туршлагын сан, алдааны мэдээний санг нэгдсэн удирдлагаар ханган ажиллуулна..” гэж нэмэв.
11	Чанарын албаны зарчимд хараат бус гэж нэмэх	3.6-д “...хараат бус...” нэж нэмэв

Эрүүл мэндийн чанарын хяналтын зөвлөлийн гишүүдийн санал

1	Чанарын албатай хариуцлага тооцох бүлгийг хууль дүрэмд нийцүүлэн өөрчлөх, хууль зөрчсөн бол тухайн хуулиараа хариуцлага тооцох тул, зөвхөн чанарын албатай хариуцлага тооцох тухай заалтыг хасах	11.6-д “...Чанарын албаны дарга, гишүүд нь энэхүү дүрэмд заасан зарчмын дагуу эрх, үүргийг хүлээн үйл ажиллагааг явуулах ба зөрчсөн тохиолдолд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журам болон холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ...” гэж өөрчлөв.
2	Эрүүл мэндийн байгууллагын шатлалаас үл хамааран чанарын баг ажиллуулах	1.2-т “...Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан эрүүл мэндийн бүх байгууллагуудад чанарын

		алба ажиллана...” гэж заав.
МХЕГ-аас ирүүлсэн санал		
	9.4 Мэргэжлийн хяналтын байгууллага нь Захиргааны хариуцлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу ажиллана гэж нэмэх ,	9.4-т “...Мэргэжлийн хяналтын байгууллага нь Захиргааны хариуцлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу ажиллан...” гэж нэмэв
	9.2-т Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоолыг 3.7.8 дахь заалтыг тусгах	9.5-д “...Чанарын алба нь дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулан, мэргэжлийн хяналтын байгууллагатай чанарын хяналт, шинжилгээ үнэлгээ, сургалтыг хамтран зохион байгуулна...” гэж нэмэв.